

ЭНЭ ДУГААРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

МАРКСИЗМ БА ЧӨЛӨӨТ ЗАХ ЗЭЭЛ

II НҮҮРТ

НИЙТЛЭЛ

Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн доктор

ШИНЭ ҮЕИЙН БИЗНЕСИЙГ ТӨР,
НАМЫНХНЫ ШУДАРГА БУС
ӨРСӨЛДӨӨНӨӨС ХАМГААЛАХ ТУХАЙД

IV НҮҮРТ



ДеФакто **ЯРИЛЦАГА**

Д.Рэгдэл
Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч,
МУ-ын ШУ-ны гавьяат зүтгэлтэн

ЗГ 1981 ОНООС ХОЙШ ШУА-Д ИТГЭСЭН НЬ
‘УТААГ БУУРУУЛАХ ШИЙДЭЛ ОЛ’
ГЭСЭН ТОМ ДААЛГАВАР БАЙВ

VI НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

ОГЦРОХ УУ, ЭС ОГЦРОХ УУ?

БҮЛЭГГҮЙ БОЛСОН АН

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ

VIII НҮҮРТ

МАНАЙ СОНИНЫ 2019 ОНЫ
I УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

МАРКСИЗМ БА ЧӨЛӨӨТ ЗАХ ЗЭЭЛ



Карл Марксын мэндэлсний 200 жилийн ой энэ жил тохиож байна. Түүний амьдрал, бүтээлийг товчлон харуулсан Дийтмар Датын “Карл Маркс” нэртэй номыг Удирдлагын академийн дэд профессор, доктор О.Цэрэнчимэд немц хэлнээс саяхан хөрвүүлж монголын уншигчдад толилуулжээ. Номын орчуулагч, нийгэм судлаачид, төр засгийн өндөр албан тушаал хашиж буй, хашиж байсан олон эрхмийг оролцуулан ХБНГУ-ын элчин сайд Стефан Дуппелын санаачилгаар 2018 оны 12-р сарын 5-нд зохион байгуулсан сонирхолтой хэлэлцүүлгийг хөтлөх үүрэг надад ногдов.

Монгол улсын түүхийн бараг далаад жил К.Марксын онолтой шууд холбоотой учир түүний онол, үзэл санааны гол нь юу байсан, яагаад түүний онолоор замнасан маш олон улс орнууд эцэстээ дампуурсан, ер нь өнөөдөр дэлхий дахинаа тулгараад байгаа гол гол асуудлыг шийдэхэд ямар нэмэртэй болох тухай энэ хэлэлцүүлэг дээр ярилцав.

КОММУНИЗМЫН ХИЙ ҮЗЭГДЭЛ

1848 онд Англид бичиж хэвлүүлсэн, К.Маркс, Ф.Энгельс нарын “Эв хамт намын тунхаг бичиг” гэх бэсрэг товхимол “Хий үзэгдэл - коммунизмын хий үзэгдэл Европоор тэнэж явна” гэж эхэлдэг. Хүн төрөлхтний хөгжилд хамгийн их нөлөөлсөн гэгдэх энэхүү улс төрийн баримт бичигт “бүх нийгмийн түүх бол ангийн тэмцлийн түүх” гээд, капитализм яваандаа коммунизмаар солигдоно гэдэг. Хорин жилийн дараа К.Маркс алдарт “Капитал” зохиолдоо капиталист нийгмийн хувьд энэ тэмцэл нь хөдөлмөрөө мөлжүүлж буй ажилчин анги, үйлдвэрлэлийн хэрэгслийн эзэн капиталист ангийн хооронд үүснэ гэжээ. Тийм учраас энэ тэмцэл үйлдвэрлэлийн хэрэгслийг аль нэг хүн биш, бүх нийтээр эзэмших хүртэл өрнөснөөр дараагийн нийгэм буюу коммунизм бий болно гэжээ.

Энэ онолыг амьдралд хэрэгжүүлэх ажил 1917 онд Орос улсад В.Лениний удирдлагаар эхлэв. Оросын “большевикууд” хаанаа буудан алж, коммунист

намын удирдлагын дор ажилчин ангийн диктатур тогтоож, хувийн хөрөнгийг хураан нийтийн болгож, тариачдын газрыг нэгтгэж хамтралынх болгов. Орос төдөлгүй аймшигт өлсгөлөнд нэрвэгдэв. Дэлхийн II дайны дараа коммунизм хүрээгээ тэлж зүүн Европын, Азийн олон оронд тархлаа.

1980-аад оны сүүлээр социалист гэгдэх эдгээр орнуудын эдийн засаг, улс төрийн систем бүрэн дампуурав. Олон хүн хэлмэгдэж, барууны орнууд руу дүрвэж байлаа. Улс төрийн дарангуйллын коммунист туршилт дэлхий нийтээр зуугаад сая хүн, түүний дотор Хятадад 65 сая, Орост 25 сая, Монголд 40 мянган хүний амийг авч одсон ажээ.

Үйлдвэрлэлийн хэрэгслийг капиталистуудаас хүчээр хураан авч, нийтийн эзэмшилд коммунизм бий болдоггүй ажээ. Аль ч улс орны хөгжлийг хувийн өмч, чөлөөт зах зээлгүйгээр төсөөлөх боломжгүй гэдгийг түүх батлав. Коммунизм үнэхээр, аймшигт хий үзэгдэл ажээ.



► КАПИТАЛИЗМЫН ДОТООДЫН ЗӨРЧИЛ

Коммунизм системийн хувьд нуран унасан ч тодорхой улс орнуудад нийтийн өмчтэй, эв хамт нийгэм байгуулах үзэл санаа эдүгээ бүрэн алга болоогүй л байна. Хойд Солонгос, Куба, Венесуэл зэрэг арваад оронд энэ туршилт үргэлжилсээр байна. Олон сая хүн дарангуйлагчдын атганд, үг хэлэх эрх чөлөөгүй, ядуу тарчиг амь зууж байна.

Марксын тайлбарласан үйлдвэрлэлийн хэрэгслийн эзэд болон тэдэнд ажиллаж буй хөлсний ажилчдын хоорондын тэмцэл 21-р зуун гараад хурцдах хандлагатай боллоо. The Economist сэтгүүлийн 2016 оны судалгаагаар Америкийн залуучуудын хагасаас илүү нь капитализмыг дэмжихгүй байна. Капиталист нийгэмд иргэдийн орлогын зөрүү улам өссөнөөр ядуурал буурахгүй байна. Францад болж буй “шар хантааз” хөдөлгөөн үүний тод илрэл юм. Шатахууны үнийг нэмэх шийдвэрээ Засгийн газар нь цуцалсны дараа ч энэ хөдөлгөөн өргөжсөөр Ерөнхийлөгч Э.Макроныг огцрохыг шаардаж байна. Босогчид амьдралын зардал улам өсч, нийгмийн дунд, доод давхарга улам бүр ядуурч, төрийн зардал, тансаглал томорсоор, түүний хэрээр татвараа нэмэх болсныг эсэргүүцэж байна. Француудын 75 хувь нь энэ тэмцлийг дэмжиж байгаа ажээ. Аргаа барсан

КАПИТАЛИЗМЫН ЭЭЛЖИТ ЗАСВАР

Капитализм бол чөлөөт эдийн засгийн систем бөгөөд зөвхөн энэ систем хүн төрөлхтний түүхэнд хамгийн их баялагийг бүтээж, харьцангуй хамгийн олон хүний амьдралыг дээшлүүлсэн юм. Улс төрийн ардчилсан систем тогтсоноос хойш хүн төрөлхтний түүхэнд хамгийн олон хүнд улс төр, эдийн засгийн эрх чөлөө олгож чадсан юм.

Энэ системийн оршин тогтнох үндэс бол хувийн өмчид тулгуурласан чөлөөт зах зээл, өрсөлдөөн. Төр бол иргэдийнхээ өмч хөрөнгө, эрх, аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй. Иргэд чөлөөт зах зээлд итгэхгүй, чөлөөт өрсөлдөөн алга болж эхэлвэл энэ систем хямралд ордог. Төр засаг нь хэт их томорч, чөлөөт өрсөлдөөн суларсны улмаас эдийн засаг, нийгмийн хямрал тохиоход системд түүхэн засвар хийж ирсэн юм. Үүнд 80-аад онд Англи, АНУ-д хийгдсэн М.Тэтчэр, Р.Рейганы шинэчлэлийг дурдаж болно.

Харин энэ удаа 21-р зууны хориод онуудад капитализмын их засварыг гурван чиглэлээр

Ерөнхийлөгч Э.Макрон 2019 оноос эхлэн сарын цалингийн доод хэмжээг 100 еврогоор нэмэхээр болов.

2013 онд Францын эдийн засагч Томас Пикетти (Thomas Piketty) “XXI зууны Капитал” гэх номоо гаргасан нь нэлээн шуугиан тарьж байна. Тэрээр дэлхийн хөгжлийн гурван зуун жилийн өгөгдлийг судлан орлогын тэгш бус байдал эрчимтэй өсч буй, Марксын капитализмын зөрчлийг тодорхойлсныг үнэн болохыг баримтжуулжээ. Тэгш бус байдал өсөх нь жам ёсны үзэгдэл учраас Пикетти өсөх шатлалтай татварыг санал болгожээ. Гэвч Францад өндөр орлогоос 50 хувиас илүү татвар авч байгаа учир баячууд нь өөр улсын иргэншил аваад, бага татвартай оронд хөрөнгө оруулалт хийх болжээ.

Германд өндөр болон бага орлогын ялгааны үр дагаврыг бууруулах, гарааны ижил тэгш нөхцөл олгохын тулд боловсролыг бүх түвшинд нь үнэгүй олгох болсноор ядуу айлын хүүхдэд ч амжилтанд хүрэх боломж олгож иржээ. Төрөхдөө витамин дутагдалтай хүүхэд өсөхдөө оюун ухаан, бие бялдрын хөгжил дутуу байдаг учир барууны орнуудад бүх жирэмсэн эхчүүдэд төлбөргүй витамин тарааж байна.

хийж зах зээлийн чадварыг сэргээхийг The Economist сэтгүүлээс санал болгожээ (November 15, 2018. p.13). Эхлээд, дата болон оюуны өмчийн эрхийг хамгаалахдаа одоо байгаа эрхээс гадна шинэ бүтээлийг өдөөхөд, юуны өмнө технологийн үйлчилгээ авч байгаа хэрэглэгч өөрийнхөө мэдээллийг хэнд өгөхөө шийдэх эрхийг баталгаажуулах; дараа нь, Засгийн газрууд бизнес эхлүүлэхэд өрсөлдөөний биш заалтууд, тодорхой мэргэжлийн лиценз шаардах, лоббистуудын бэлдсэн олон төрлийн тусгай зөвшөөрлүүд шаардахыг халах (өнөөдөр АНУ-ын ажиллах хүчний хорин хувь нь мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй. Гэтэл 1950 онд энэ нь ердөө 5 хувь байжээ), эцэст нь монополийн эсрэг хуулийг 21-р зуунд тохируулж өөрчлөх хэрэгтэй байна (монополь давуу талаа ашиглаж хэрэглэгчийн эрх ашгийг хохироож байгаа ямар ч компанийн бизнесийг нь зогсоох) зэрэг болно.

2018.12.13



НИЙТЛЭЛ

ДЭЛГЭРИЙН УЯНГА
өмгөөлөгч, хууль зүйн доктор

ШИНЭ ҮЕИЙН БИЗНЕСИЙГ ТӨР, НАМЫНХНЫ ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНӨӨС ХАМГААЛАХ ТУХАЙД

Европт бизнес эхлүүлэх хялбар. Нэг нягтлан бодогч олж авна. Дараа нь орлого олох ажилдаа анхаарлаа төвлөрүүлнэ. Бизнес нь овоо гайгүй болоод ирвэл боломж өөрөө гүйгээд ирнэ. Чөлөөт, шударга өрсөлдөөн, шинэ санаачилгыг дэмжих өрсөлдөөн, оюуны өмчийн хуулиуд “бацаануудын” бизнесийн замыг дардан болгоно. Төрийн оролцоотой сургалт, зээлийн хөтөлбөрөөр дэмжинэ. Ингээд жижигхэн интернэт худалдаа нь хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болтол өсч 40 хүрээгүй саятан залуусыг төрүүлэх Zalando-ийн амжилт гэх мэт түүх бичигддэг.

Монголын нөхцөл байдлын тухай нурших хэрэггүй. Залуу хүнийг ийш, тийш гүйлгэж цагийг нь барна. Санамж бичиг, татварын алба, лиценз гэх мэт олон цаас, зардал чирэгдэл болно.

Нааш, цааш явуулдаг нь заримдаа цаанаа

бяцхан учиртай. Зах зээл нь эзлэгдээд, жижигхэн хөөрхөн картелиудын гарт орчихсон хэрэг. Картелиуд нь ихэнх тохиолдолд нам, агентлаг, сум гэх мэтийн даргатай холбоотой. Зах зээлд шинэ өрсөлдөгч гарч ирмэгц бяцхан хошгируулаад, хэсэг гүйлгүүлж байгаад чимээгүй болохыг нь хүлээнэ... Ахисан шатанд авлига гэх айхтар үг орж ирнэ.

Энэ тогтолцооны хохирогчид нь муу чанарыг өндөр үнээр авч, мөнгөний боол болсон хэрэглэгчид.

Чөлөөт, шударга өрсөлдөөнийг хангах нь нийгмийн гэрэл гэгээ, өөдрөг үзлийн эх ундарга болсон залуу үед тустай... Одоогийн байдлаар Zalando-ийн үндэслэгчид шиг залуус монголоос төрөхгүй. Тэд эртхэн гадаад руу гарсангүй гэж харамсана эсвэл гадаад руу гарч сураг тасарна гэвэл нэг их хэтрүүлэг болохгүй.

ҮНДСЭН ХУУЛЬ

Төр бүхнийг өмчилж, иргэдэд чөлөөтэйгээр бизнес эрхлэх эрх чөлөөг өгөхгүй байсан социалист тогтолцоог Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар халсан. Өнөөдөр тус хууль нь одоогийн эдийн засгийн тогтолцооны шаардлагыг хангахгүй болжээ.

Төрөөс зах зээлийн чөлөөт, шударга

өрсөлдөөний нөхцлийг дордуулах замаар иргэний өмчлөх эрх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, эрхлэх үндсэн эрхэд халдахгүй байх ёстой. Жишээ нь: Европын эрх зүйн практикт төрийн аливаа дэмжлэг, зээл, бусад арга хэрэгсэл нь иргэний өмчлөх эрх, ажил мэргэжлийн эрх чөлөөнд халдахгүй байхыг баталгаажуулах

зорилготой хууль тогтоох шатан дахь процессын хяналт, иргэд үндсэн эрхээ Үндсэн хуулийн шүүхээр хамгаалуулах замаар хангуулдаг хууль гарсны дараах хяналт гэж байдаг. Европын эрх зүйн 'principle of subsidiarity', 'principle of proportionality' гэсэн зарчмууд нь хууль тогтоох замаар зах зээлийг зохицуулах хууль тогтоогчийн эрх мэдлийг хязгаарлаж, өөрийнхөө төлөө өөрөө хөдөлмөрлөж баялаг бүтээх иргэний үндсэн эрх чөлөөг хамгаалдаг.

Монгол Улсын хувьд өмчийн хамгаалал, бизнесийн эрх чөлөөг илүү тодорхой болгосон заалтуудыг Үндсэн хуульд оруулж өгөх шаардлагатай байна. Мөн хууль тогтоох шатанд хууль нь зах зээлийн өрсөлдөөнд хэрхэн нөлөөлөх талаар урьдчилан дүгнэлт гаргуулж, хэлэлцүүлэг өрнүүлдэг болох хэрэгтэй. Түүнчлэн Үндсэн хуулийн цэц гэх байгууллагыг УИХ-д нэгтгэх эсвэл Хүний эрхийн шүүх (Үндсэн хуулийн шүүх) байгуулах хэрэгтэй байна.

ӨРСӨЛДӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Зах зээл, өрсөлдөөн дангаараа сайн сайхан нийгмийг авчрахгүй. Дэлхийн II дайны дараа Европ тивд зоригтой, тууштай хийж эхэлсэн чухал зүйл бол шүүхийн хараат бус байдлыг хангахын зэрэгцээ шүүхтэй ойролцоо хараат бус байдалтай Өрсөлдөөнийг зохицуулах газартай болсон явдал юм. Өнөөгийн Европт Өрсөлдөөнийг зохицуулах газрууд нь зах зээлийн чөлөөт байдлын тухай салбарын болон бүх улсын судалгааг хийдэг. Жнь: Бензиний зах зээлийн тухайд гэхэд нийлүүлэгчид нь хэн бэ?, түгээлтийн тогтолцоо ямар байна вэ?, үнэ хэрхэн бүрэлдэж байна вэ? гэх мэтээр тухайн зах зээлийн тухай маш тодорхой ойлголттой болдог. Үүний үндсэн дээр хэрэглэгчийг хамгаалах, зах зээлийн чөлөөт, шударга өрсөлдөөнийг хангах төрийн арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болдог.

Монгол Улсын тухайд одоогийн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын хараат бус байдлыг хуулиар хангаагүй бөгөөд тус газар нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөний байдлын тухай олон нийтэд нээлттэй судалгаа хийдэггүй.

ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТ

Монгол Улсад шинэ бүтээл, барааны тэмдгийг бүртгүүлж патент, гэрчилгээ авч хамгаалуулдаг. Шинжлэх ухаан, уран зохиолын гэх мэт бүтээлүүдийг мөн бүртгүүлж зохиогчийн эрхийн гэрчилгээ авах боломжтой байдаг.

Монголын оюуны өмчийн тогтолцоонд хоёр томоохон шинэчлэлийг хийж байж, шинэ санаачилга, шинэ үеийн бизнесийг хамгаалах боломжтой болно. Нэгдүгээрт, өнөөгийн шинэ бүтээл, барааны тэмдгийн бүртгэлийн тогтолцоо нь өөрөө сэтгэж бүтээгээгүй, үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэггүй байж патент, гэрчилгээ гүйж очоод авчихдаг, бусад шударга бизнес эрхлэгчдэд саад болж, тэднийг "саадаг" компаниудыг ч бүтээсэн байна. Энэ тогтолцоог халах, үнэхээр хийж бүтээж байгаа нь эрхээ эдлэх боломжийг олгодог тогтолцоо шаардлагатай байна.

Хоёрдугаарт, оюуны өмчийн асуудлыг Оюуны өмч хариуцсан агентлаг, Гаалийн байгууллага болон Иргэн, Захиргааны шүүхүүд давхар хариуцдаг. Энэ нь бодит үр дүн муутай, зардал чирэгдэл, хүнд сурталтай тогтолцоо юм. Ирээдүйд Оюуны өмч хариуцсан агентлаг нь зөвхөн бүртгэл хийдэг байх ёстой. Оюуны өмчийн бүртгэлтэй холбоотой маргаан, өмчлөгчийн эрхийн хэрэгжилтийн асуудлыг дан ганц Иргэний хэргийн шүүх хариуцах тогтолцоог бий болгох шаардлагатай. Ингэхдээ Гаалийн байгууллага зарчмын хувьд зөвхөн Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх замаар хил дээр оюуны өмчийн зөрчилтэй барааг саатуулах, устгах эрхтэй байх ёстой.



Д.РЭГДЭЛ

Шинжлэх Ухааны Академийн
Ерөнхийлөгч, МУ-ын ШУ-ны
гавьяат зүтгэлтэн

ДеФакто ЯРИЛЦЛАГА

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

ЗГ 1981 ОНООС ХОЙШ ШУА-Д ИТГЭСЭН НЬ 'УТААГ БУУРУУЛАХ ШИЙДЭЛ ОЛ' ГЭСЭН ТОМ ДААЛГАВАР БАЙВ

Д.Рэгдэл нь 1976 онд ЗХУ-ын Харьковын их сургуулийг Биохимич мэргэжлээр төгсөж 1985 онд Германы Гумболдтын их сургуульд доктор, 2001 онд химийн шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан. 2002 оноос ШУА-д гишүүнээр сонгогдсон. 1996 онд Монгол улсын Төрийн соёрхол, 2006 онд Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.

Д.Ж: Та ШУА-ийн үүсэл, хөгжил болон ач холбогдлын тухай ярьж өгнө үү.

Д.Р: Аливаа улс оронд мэдлэг үйлдвэрлэдэг, улс төрөөс хараат бус байгууллага хэрэгтэй байдгийг түүхээс харж болно. Тийм учраас 1921 онд Ардын Засгийн Газар байгуулагдаад таван яам байгуулахын хажуугаар Судар бичгийн хүрээлэн байгуулсан байгаа юм. Түүхчдийн үзэж байгаагаар тухайн үеийн Судар бичгийн хүрээлэн бол орчин үеийн шинжлэх ухааныг хөгжүүлэх яам байсан. Энэ байгууллага маань олон үе шат дамжиж явсаар 40 дэх жилдээ буюу 1961 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр Монголын ШУА-ийг анх байгуулсан түүхтэй. Монгол улсад хөдөө аж ахуйн хоршоолох хөдөлгөөн төгсгөлийн шатандаа ороод, хөгжлийнхөө зорилгыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орон болгох эрчимтэй хөгжлийн шатандаа шилжих үедээ ШУА-ийг байгуулсан тул төрийн бодлогоор байгуулагдсан гэсэн үг. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орны дараагийн шат нь үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн орон байдаг бөгөөд үүнд шинжлэх ухаан хэрэгтэй учраас ШУА-ийг чухал гэж үзсэн.

Д.Ж: Өнөөдөр ШУА ямар бүрэлдэхүүнтэй ажиллаж байна вэ?

Д.Р: Манай ШУА харьяа 10 эрдэм шинжилгээний хүрээлэнтэй, нийт 1000 хүн ажиллаж байгаагаас 880 нь эрдэмтэн судлаачид бөгөөд үлдсэн 120 нь захиргаа, аж ахуйн ажилтнууд. 10 хүрээлэнгийн 6 нь байгалийн ухааны, 4 нь нийгэм, хүмүүнлэгийн чиглэлээр судалгаа явуулдаг. Хүрээлэн бүрийнхээ онцлогоос хамаараад судлаачдын тоо ялгаатай. Нийгэм, хүмүүнлэгийн хүрээлэнд ажиллагсдын тал нь докторын зэрэгтэй байхад байгалийн ухааны хүрээлэнд ажиллагсдын 30-35 хувь нь докторын зэрэгтэй байна. Ойрын хугацаанд бид үүнийг 50 хувьд хүргэхээр зорьж ажиллаж байгаа.

Д.Ж: ШУА-ийн байгалийн ухааны хүрээлэнгийнхний тал нь докторын зэрэгтэй байна гэж юу гэсэн үг вэ?

Д.Р: Байгалийн ухаан бол бүтээгч шинжлэх ухаан. Байгалийн ухаанд боловсролын докторын зэрэг хамгаалсан хүнийг тухайн чиглэлээрээ цаашдаа

бие дааж судалгааны ажил хийх чадвартай болсон байна гэж дүгнэдэг. Тиймээс бие даан судалгаа хийх чадвартай судлаач 50 хувь нь болчихвол хүний нэгдсэн хөгжлийн хувьд ахиц гарах юм байна гэж үздэг. Түүнээс зэрэг цол хамгаалахгүй яваад байгаадаа биш юм. Эрдэм шинжилгээний ажилтны дундаж нас ШУА-ийн хэмжээнд 38 байгаа нь 1980, 1990-ээд онтой харьцуулахад маш залуужиж байгаа. 35 хүртэлх насны судлаачид нийт судлаачдын 54-55 хувийг эзэлж байна. Гэхдээ тэдэнд зааж, зөвлөх ахимаг насны судлаачид бага байгаа нь зарим талаараа тийм ч сайн зүйл биш.

Д.Ж: ШУА санхүүжилтээ хаанаас авдаг вэ?

Д.Р: ШУА анх байгуулагдсан цагаасаа улсын төсвөөс санхүүжиж ирсэн. Энэ нь манайд шинжлэх ухаан хөгжиж ирсэн онцлог уламжлалтай холбоотойгоос гадна үйлдвэрлэлийн бааз муутай холбоотой. Дэлхийн шинжлэх ухааны жишгийг харахад 65-70 хувийн санхүүжилтээ бизнесээс буюу үйлдвэрлэлээс, үлдсэнийг нь төрөөс авсан байдаг. Манайх энэ чиглэл рүү явах ёстой юм.

Д.Ж: Улсаас хэдий хэмжээний төсөв авдаг юм бэ?

Д.Р: Манай бүх санхүү Шинжлэх ухаан, технологийн санд байрладаг. Сүүлийн 4, 5 жилийн дунджаар төрөөс жилд 10-11 тэрбум төгрөгний санхүүжилт авч байна.

Д.Ж: Энэ хангалттай юу?

Д.Р: Хангалтгүй гэхэд багадаа л даа. Үлдэгдлийн зарчмаар санхүүжүүлдэг санхүүжилтийн хэмжээ сүүлийн 4, 5 жилд өөрчлөгдөөгүй.

Д.Ж: Барууны орнууд Research and Development буюу судалгаа болон хөгжүүлэлтийн үйл явцыг бизнестэй холбож өгдөг гэж та ярьж байна. Манайд ингэж хийхэд юу саад болж байна вэ?

Д.Р: Хамгийн гол асуудал нь бизнес дэх технологийн мэдрэмж хөгжиж өгөхгүй байна. Технологийн мэдрэмжийг шинжлэх ухааны салбарт бий болсон технологийг олж мэдээд үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг хэлдэг гэж ойлгож байгаа. Арваад жилийн өмнө Шинжлэх ухаан, технологийн сангаас тодорхой чиглэлийн төслүүдийг бизнесийн байгууллагуудад

санал болгоод зардлын 20 хувийг танайх гаргаад 80 хувийг нь улсын төсвөөс гаргаад 2 жил судалгаа хийсний дараа гарч ирсэн аргыг нь үнэгүй хэрэгжүүлээд явахыг санал болгосон 25 төслөөс хоёрт нь л хүсэлт ирж байсан. Шинжлэх ухаанаас гарч байгаа технологийг үйлчилгээ болгож шилжүүлэхэд дунд нь заавал нэг шат дамжлага гарч ирж байдаг. Социализмын үед бүгд улсынх байсан болохоор үйлдвэр бүрийн зардалд шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрүүлэх зардал гэж гаргадаг байсан. Үйлдвэрийн дарга тэр зардлаа ашиглаад шинжлэх ухааны ололтыг үйл ажиллагаандаа оруулаад явж болдог байсан. Одоо бол хаана ч тийм зардал байхгүй. Гарч ирсэн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг хуулиараа яам хариуцдаг.

Д.Ж: Тэгвэл та нар өөрсдөө бүтээсэн мэдлэгээ бизнес болгох ямар боломж байна вэ?

Д.Р: Энэ олон жил асуугдаж байгаа хариулахад төвөгтэй асуулт. Яам, ШУА нийлж байгаад цэгц ажлууд гээд гарч ирсэн технологийг бүтээгдэхүүн болгох зардлыг нь өгөөд жижиг цех, үйлдвэрүүд олныг байгуулж үзсэн. Энэ ажил арав гаруй жил явж байгаад эрх зүйн орчны дутагдлаас болоод зогсчихсон. Яагаад гэвэл тэр цэгц ажлын үр дүнд хэний өмч болох уу гэдэг нь шийдэгдээгүй.

Үүний дараа 2014 оноос Хүрээлэн их дээд сургуулиудын дэргэд гарааны компани байгуулж эхлээд одоогийн байдлаар 6 компани байгуулагдсан, 4 компани байгуулах захиалгатай явж байгаа. Энэ гарааны компани бол инновацийн тухай хуулиар тодорхой хөнгөлөлттэйгээр бүтээгдэхүүнээ гаргаад явах ёстой байдаг. Гарааны компаниудад бас нэг асуудал байгаа нь судалгаа хийсэн эрдэмтэн нь өөрөө үйл ажиллагаагаа явуулах, сурталчлах зэрэг бүх үйл ажиллагааг нь гардаж хийх болчихоод байгаа юм. Эдгээрээс гадна хамгийн том асуудал нь шинжлэх ухаан, технологийн салбарт мэдлэг бий болгох үйл ажиллагааны зардал бага байдаг. Бага зардлаар хийж байгаа ажлаас гарч байгаа үр дүн нь том байж чадахгүй байгаа юм. "Том завиар холын аянд" гэж хэлц үг ч байдаг.

Д.Ж: Нөгөө талаасаа өнөөдөр байдлыг цоо шинээр харах шаардлагатай болж байгаа. Мэдлэг гэдэг бол яг цаг шиг. Хэрэгтэй үедээ л ашигладаг. Мэдлэгийг үнэт зүйл, мөнгө болгохгүй бол тийм мэдлэгээр яах юм? Мөнгө гэдэг чинь эрх чөлөөний үндэс шүү дээ. Таны хэлсэн гурван асуудлын хоёр нь өмчийн асуудал байна. Өмчгүйгээр амжилтанд хүрнэ гэж байхгүй учраас бид социализмаас капитализм руу шилжсэн. Энэ хоёр нийгмийн ялгаа нь хувийн өмч.

Д.Р: Манай шинжлэх ухаанаас гарч байгаа үр дүнгүүд дандаа жижигхэн байна. Энэ жижиг үр дүнгээр амьдралаа аваад явна гэдэг итгэл байхгүй байна. Яагаад гэвэл сүүлийн 20, 30 жил энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс яаж үлдэж хоцрох вэ гэдэг дээр их төвлөрсөн. Өмчийн асуудал дээр эрх зүйн асуудлыг нь чөлөөлж өгөх ёстой. Гарааны компани, цэгц ажил дээр гэхэд хэний өмч байх вэ гэдэг нь шийдэгдээгүй. Бид нар хуулиа өөрчлөхийг л санал болгохоос өөр юм хийж чадахгүй. Гарааны компанид ажиллаж байгаа

хүн маань санаа нь хоёрдоод байна шүү дээ. Төрийн оролцоотой бий болсон юм гээд төр өөрөө авчихвал цаашаа хөгжих замд саад болно.

Д.Ж: Энэ бол шилжилтийг дутуу хийж байгаа, хувийн өмчийг ойлгохгүй, хүндлэхгүй байгаагийн их том хэлбэр л дээ. Ерөнхий сайд асан Ж. Эрдэнэбат утааг арилгах шинжлэх ухааны үндэслэлтэй шийдэл гаргах даалгавар өгсөн тухай яриач?

Д.Р: Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат /2016.12.20/ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт /БСШУС/-ын сайд асан Ж.Батсуурь болон намайг гэнэт дуудан Улаанбаатарын утааг эрчимтэй бууруулах шинжлэх ухааны үндэслэлтэй, хамгийн боломжит шийдлийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон. Энэ бол нийт шинжлэх ухааны салбарынханд баяртай мэдээ шиг сонсогдож байж магадгүй. Учир нь хэзээ ч ерөнхий сайд, Засгийн газар нь Шинжлэх ухааны академид итгээд ийм том даалгавар хүлээлгэж байгаагүй. Миний мэдэхээр 1981 онд сансрын нислэгийн эрдэм шинжилгээний програмыг боловсруул гэж байснаас хойш ийм том итгэл хүлээлгэсэн даалгавар өгч байсангүй. Утааны асуудлыг шийдэхийн тулд 140-150 тэрбум төгрөг зараад арваад жил үзсэн боловч үр дүн гарсангүй. Яагаад үр дүн гараагүйг ч монголчууд мэдэж байгаа байх.

Д.Ж: Одоо яах гэж байна вэ?

Д.Р: Сүүлийн үед миний өрөөний үүднээс хүмүүс салахаа байлаа. Дэлхийн бүх орон л утаагаар дамжсан. Үүнийг одоогийн техник технологиор хэрхэн шийдэх вэ гэдгийг бид тооцож олох ёстой. Улсуудын туршлагаас дурдвал түлшээ сайжруулдаг. Энэ нь утааг тодорхой хэмжээгээр бууруулахаас бүрэн арилгахгүй. Мөн улс орны онцлогоос хамаараад хийгээр асуудлаа шийдэж байна. Гурав дахь хамгийн түгээмэл шийдэл бол цахилгаан эрчим хүч, цахилгаан зуух хэрэглэх юм.

Д.Ж: Түлшээ сайжруулж чадсангүй, хийжүүлэх хий алга. Монгол Улсын эрчим хүчний хэрэгцээ нийлүүлж чадахаасаа хоёр дахин илүү байна. Ийм учраас атомын цахилгаан станц барина гэж ярилцлага өгсөн байсан. Яагаад барих хэрэгтэй гэж бодож байна вэ?

Д.Р: Ялангуяа Улаанбаатар хотод цахилгаан эрчим хүчний хангамж эцэстээ тулчихсан гэж мэргэжилтнүүд ярьдаг учраас цаашдаа нэмж байж л хэрэглээгээ өргөсгөх боломжтой. Төв суурин газарт нэмэлт эрчим хүчний эх үүсвэр зайлшгүй хэрэгтэй. Монголд атомын цахилгаан станц барих нь энэ асуудлыг шийдэх нэг гарц юм гэж нэг ярилцлагадаа хэлсэн бөгөөд Улаанбаатар хотын утаатай шууд холбож ярьсан зүйл биш л дээ. Дэлхий нийтээр атомын эрчим хүчийг хаягдал гардаггүй, цэвэр эрчим хүч гэж хардаг. Герман гэхэд атомын цахилгаан станцын аюулгүй байдлын хамгаалалтыг бүрэн хангах төгс шийдэлд бараг хүрчихсэн.

2017.01.11-нд цацагдсан

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг

<http://jargaldefacto.com/article/d-regdel-regdel-duger>
холбоосоор үзнэ үү.



ДеФакто тойм

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2018.12.09-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ОГЦРОХ УУ, ЭС ОГЦРОХ УУ?



Үйл явдлын товч:

Лу.Болд, Д.Хаянхярваа, Ж.Батзандан, Л.Оюун-Эрдэнэ гэсэн УИХ-ын дөрвөн гишүүн Их Хурлын даргыг албан тушаалаасаа огцрохыг шаардаж хаяг, лоозон барьж эсэргүүцсэн үйл явдал болсон. Эдгээр гишүүд нь УИХ-ын даргыг 60 тэрбумын хэрэгт холбогдсон, энэ асуудлаар нийтийн сонсгол хийхгүй байгаа мөн ээлжит бус чуулган хуралдуулаагүй зэрэг үндэслэлээр шаардлага тавьж байгаа.

Мөн дээрх дөрвөн гишүүнээс гадна Засгийн газрын зарим гишүүд чуулгандаа оролцохгүй байгаа. Энэ асуудлаас болоод чуулганы ирц хангалтгүй байсаар байна. ЗГ-ын гишүүн Я. Содбаатар, Ц.Цогзолмаа нарыг огцруулахаар болсноо ЗГ-ын хэвлэл мэдээллийн албанаас мэдэгдсэн.

Дүгнэлт тайлбар:

Ардчилсан хуулийн засаглалтай оронд байх ёстой төрийн эрх мэдлийн засаглалын гурван хэлбэр гэж байдаг. Хууль, Шүүх, Гүйцэтгэх засаглал. Эдгээрийн харилцан тэнцвэртэй байх зарчим МУ-д удаан алдагдсан тул засаглалын хямрал өөрийн эрхгүй гарч ирж байна. Энэ бүхнийг тухай бүрт нь хянаад, зохицуулаад явах ёстой байсан юм. Тэгэхийн тулд бид тусгай нэг шүүхтэй буюу тэр нь Үндсэн Хуулийн Цэц, ҮХЦ цаг тухайд нь арга хэмжээ авч, иргэдийн үндсэн эрхийн баталгаа болж чадсан бол энэ бүхэн болохгүй байсан.

Мөн анх удаа давхар дээлтэйгээсээ болж ЗГ нь хохирох бус УИХ нь хохирч байгаа тохиолдол гарч байна. Нэр бүхий УИХ-ын гишүүд албан тушаалаа ашиглан ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас тэрбум төгрөгөөр тоологдох хэмжээний зээл авсан нь илэрчихсэн байхад ёс зүйн хариуцлага хүлээж албан тушаалаа өгөхгүй, харин ч буцаагаад төлсөн юм чинь болоо юм биш үү гэсэн байдалтай байгаа нь манай төрийн ёс зүйн хэм хэмжээ



Jargal Dambadarjaa
@jargal_defacto

60 тэрбумын нээлттэй сонсгол явуулахыг дэмжээгүй гишүүдийг дахин сонгохгүй байхыг Монголчууддаа уриалж байна. Тэд бол авилгаас хүртэгсэд, Монголын хөгжлийг гацаагсад юм аа. Бүгдэд хүргэнэ үү ах дүүс нараа

Translate Tweet

12:27 PM - 1 Jul 2018

963 Retweets 939 Likes

36 963 939

хаана байгаа, хэний уланд гишгэгдсэнийг ил тод харуулж байна.

Нөгөө талаас улс төрийн намууд институцийн хувьд бэхжиж чадахгүй байгаа. 28 сангийн зөвхөн нэг нь илрэхэд л ийм байна. Эдгээр сангуудын хажууд “жинхэнэ” том мөнгөний хэрэг болох үнэ тогтворжуулах хөтөлбөр, хаадын нэртэй бондууд гээд явбал олон юм гарч ирнэ.

Дээр дурдсан хямрал эсэргүүцэл үзүүлээд байгаа дөрвөн гишүүний үйлдлээр тод илэрч байна. Дөрвөн гишүүний үйлдэл энэхүү хямралыг шийдэх цаг ирснийг л сануулаад байгаа хэрэг. Ерөнхий сайд У.Хүрэлсүх их олон амлалт өгч байгаа. Хуулиар УИХ-ын дарга огцрох таван нөхцөл байдаг. Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт:

1. Нас барсан,
2. Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг УИХ хүлээн авсан,
3. Хүндээр өвчилсний улмаас цаашид үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гаргасныг УИХ хүлээн авсан,
4. Үндсэн Хуулийн Цэц УИХ-ын даргыг огцруулах үндэслэлтэй гэснийг УИХ хүлээн авсан,
5. Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоолоор батлагдсан бол УИХ-ын даргыг үүрэгт ажлаас нь хуулийн хүрээнд огцруулж, чөлөөлж болно гэж заасан байдаг. Энэ бүхнээс өнөөгийн байдалд тохирох нь албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөхөөс өөр аргагүй байгаа. Ер нь бол огцрох нь огцорч л таарна. Гагцхүү хэзээ вэ гэдэг нь л тодорхой бус. Гэвч удах тусмаа хямрал гүнзгийрч, тэмцлийн

өөр хэлбэрт шилжинэ гэж эсэргүүцэж байгаа дөрвөн гишүүн амласан байгаа. Аль ч тохиолдолд өнөөгийн улс төрчдийн үнэн төрхийг бид харж байна. Нийтийн хөрөнгийг завшсан энэ бусармаг үйлдэл хэзээ нэгэн цагт илрэх л ёстой байсан. Энэ мэтчилэн илрээд эхлэхэд нь ард түмэн заавал хариуцлага тооцно. МУ-ын ардчилал ийнхүү нэг алхам урагшилж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

Төрийн эрхийг ээлжлэн болон эвсэн барьж байгаа хоёр нам бол зарчмын хувьд яг адилхан зөрчилтэй. Тиймээс ч бид одоо МАНАН жаахан шингэрээд ирэхээр энэ МАНАН яаж монголын төр засгийн бодит төрхийг нуун дарагдуулж, биднийг төөрүүлж байсныг харж

байгаа юм. Хоёр намд хоёуланд нь үлгэр жишээ болсон шударга манлайлагч байхгүй, зарчмын алдаагаа дотроо ил тод хэлэлцэж чадахгүй байна. Энэ нь ужгирсаар яваад монголын төр засгийг ард иргэддээ биш цөөхөн олигарх хүмүүст үйлчилдэг машин болгосон байна.

Энэ хоёр намыг нам гэхэд ч хэцүү. Учир нь энэ хоёр намын гишүүд нь намынхаа удирдлагаас санхүүжилтээ хаанаас авч байгаа, юунд зарцуулаад байгааг асууж чадахгүй хэмжээнд хамааралтай болсон, гишүүд нь энэ эрүүл байдлыг шаардахаас илүү ингэж бохир байх нь өөрсдөд нь ямар ашигтай вэ гэж хардаг болсон тул энэ хоёр нам цаашаа бэхжиж чадахгүй юм шиг байна.

БҮЛЭГГҮЙ БОЛСОН АН



Д.МУРАТ



Ж.БАТЗАНДАН



Лу.БОЛД

Үйл явдлын товч:

Засгийн газрыг огцруулахад намын байр сууринаас эсрэг санал өгсөн гэсэн шалтгаанаар парламент дахь гишүүддээ Ардчилсан нам хариуцлага ногдуулахаар болсон. Ж.Батзанданг намаас хөөж, Лу.Болд, Д.Мурат нарыг дөрвөн жил сонгуульд нэр дэвших эрхийг нь хассан. Гэтэл удалгүй УИХ-ын гишүүн Лу.Болд намын гишүүнчлэлээсээ татгалзаж байгаагаа мэдэгдсэн. Одоогоор УИХ-д Ардчилсан намаас 9 гишүүн байгаа. Наймаас доошгүй суудалтай нам УИХ-д бүлэгтэй байдаг. Найман гишүүн хүрээгүй тохиолдолд бүлэг тарах ёстой. Ингээд АН УИХ-д бүлэггүй боллоо.

Дүгнэлт тайлбар:

АН-ын дүрмийг үзэхэд гишүүн нь татвараа төлөхөөс гадна заавал андгай өргөдөг юм байна. Дүрмийн 3-р бүлгийн 5-р заалтад уг дүрмийнхээ 3-р бүлгийн олон заалтыг зөрчиж мөн гэмт хэрэг үйлдэж, хэрэг нь шүүхээр тогтоогдсон байвал намын гишүүнээсээ хасна гэсэн байна лээ. Харин ямар тохиолдолд хөөх вэ гэхээр намын хаалттай хуралдаанд гар утас, видео камер хэрэглэсэн, түүнийг ил тод болгосон, намын хурлын мэдээллийг тараасан, намын дотоод асуудлаар намын нэр хүнд, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц үйлдэл гаргасан гэх мэтээр хувь хүнийх нь эрх чөлөөг хассан заалтуудтай юм байна лээ.

Харин “Бүх шатны намын байгууллагын хурлын болон УИХ, ИТХ дахь намын бүлгийн шийдвэрийг зөрчсөн”

гэсэн заалтын дагуу Ж.Батзанданг хөөсөн биш хассан юм байна лээ, дүрмийн дагуу бол.

УИХ-ын тухай хуульд нам их хуралд бүлэгтэй байхын тулд 8 гишүүнтэй байх ёстой. Бүлэгтэй байхаар өөрийн ажлын албатай, өөрийн төсөвтэй байдаг. Мөн УИХ-ын дэгд өөрчлөлт оруулах санал тавьдаг ба завсарладаг, мөн байнгын хороонд санал оруулах эрхтэй байдаг юм байна. Энэ нь сөрөг хүчний үүргийг гүйцэтгэхэд хэрэгтэй.

Намууд өөрсдийн дүрэмтэй ч үүнийгээ хэрэгтэй үедээ л хэрэгжүүлдэг бололтой. АН-ын дүрэмд нэг заалт байгаа нь АН-ын санхүүжилт дөрвөн хэсгээс бүрддэг буюу төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, сонгуульт гишүүний суудлын хураамж, татвар хураамж, бусад зүйлс мөнгөн хандив гэж байна. Дүрмийн 8.2.5-р заалтад нь санхүүгийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод байна гэж заасан байна. 8.2-т нь “Ардчилал хөгжил сан” гэж байх ба энэ сан бодлогоо боловсруулж, санхүүжилтийг бүрэн хариуцна гэсэн байна. Тэгээд энэ сангийнх нь тайланг хайтал юу ч байсангүй. Дүрэм гэдэг нь зүгээр л ялаа алахад зориулсан цаас шиг байгаа байхгүй юу. Зөвхөн ялааг алах хэрэгтэй бол л ашигладаг.

МУ-ын их хурлын гишүүн өөрийг нь сонгосон тойргийнхоо эрх ашгийг л тэргүүн зэрэгт тавих ёстой. Энэ утгаараа сонирхол нь өөр бусадтай зөрчилдвөл УИХ-ын гишүүн ёс зүйн үүднээсээ сонгогчдын сонирхлыг хамгаалах ёстой.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ

Үйл явдлын товч:

Засгийн газраас ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү зээлийн санхүүжилт нь 300 тэрбум төгрөг байдаг бол энэ хэмжээг 500 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэхээр болжээ. Ингэснээр 8 хувийн орон сууцны зээл авах иргэд 70 хувь нэмэгдэнэ гэж ЗГ тооцсон байна. ЗГ-ын бодлого нь утааны асуудлыг шийдэх зорилгоор гэр хороололд амьдарч байгаа иргэдэд түлхүү олгохоор төлөвлөж байна гэсэн. Мөн Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж байгаа 972 айлын орон сууц 2019 оны 1-р сард ашиглалтад орно гэв.

Дүгнэлт тайлбар:

Нэмэгдэж байгаа 200 тэрбум төгрөг нь 30 хувийг урьдчилгаанд төлнө, 8 хувийн зээл авч 20 гаруй жил төлнө гээд үзвэл 3000 орчим байрны асуудал яригдаж байна. Гэтэл УБ хотод 66 мянган байр бэлэн болчихсон ба 200 мянган өрх байртай болох гээд чадахгүй байгаа.

Ипотекийн зээлийн схемийг буруу нөхцөлд буруу үед хийсэн. Олон барилгын компаниуд, банкны лоббигоор ипотекийн зээлийг зарласны дараа байрны үнэ 2 дахин нэмэгдсэн. Одоо үнэтэй юмыг хямд хүүгээр өгнө гэдэг нь нэг хүндээ бусад 9 нь байр авч өгөөд байна л гэсэн үг юм даа. Энэ мөнгийг төсвөөс гаргана, ингэснээр төсвийн алдагдал нь нэмэгдэнэ, алдагдалтай тул гаднаас мөнгө зээлнэ, мөнгө зээлэх тусмаа гадагшаа доллараар хүүг нь төлнө, төгрөгийн ханш улам унана.

Улс орны хөгжлийг байшин, машинаар хэмждэггүй. Хэдэн хүн нүхэн жорлонтой вэ гэвэл УБ хотын хагас нь тийм байна гэхээр хот феодаль хэлбэртэй байна гэсэн үг. Мөн замын түгжрэл. Бүгдээрээ гараад машиндаа суугаад зам дээр 5 цаг түгжрээд байхаар ямар хөгжлийн тухай ярих гээд байгаа юм бэ? Энэ бүхэн ипотекийн зээл алдаатай байна гэдгийг харуулж байгааг ойлгох хэрэгтэй.



Ипотекийн зээл өөрөө удаан үргэлжлэх боломжгүй. Угаасаа Монголбанк хийх ёсгүй зүйл байхад хийсэн. ЗГ-тай үнэ тогтворжуулах гэрээ гэх мэт дандаа үл гүйцэлдэх юманд гарын үсэг зурсаар байгаад ямар ч үнэ тогтоогүй, харин улс төрчдөд өөрсдөд нь л зөвхөн ашигтай байсаар ирсэн. Одоо ч байна.

Бусад оронд зээлийн хүү 8 хувь, ипотека нь 2-3 хувь л байдаг. Банкны хүү банкууд зөвхөн банкны бизнесээ л хийсэн цагт буурна. Өнөөдөр манай банкууд бүгдээрээ үнэт цаасны компанитай, даатгалын компанитай, барилгын компанитай, зарим нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй. Өөрөө бизнесийн тоглогч, хамааралтай бизнест л зээл өгдөг.

Төсвөөс өндөр үнэтэй байр авахад татаас өгч байгаагаа зогсоох хэрэгтэй. Иргэдийн орлогод яг нийцсэн байрыг барих ёстой л доо. Асуудлыг тэнд байгаа хүмүүсийнх нь оролцоотойгоор шийдэх хэрэгтэй.

Мөн төр засаг нь хулгай хийдэггүй улсад бол хотын бонд гаргаад явах ёстой л доо. Гэхдээ манайд хотын эрх зүйн байдлын хуулийг 10 жил ярьсан. Хот, аймгийн төвүүд ямар ч эрх мэдэлгүй удирдлагатай.

Машины татварыг нэмэх хэрэгтэй. Нэмэхгүй бол тэртээ тэргүй гэртээ 8 цаг унтаад, машиндаа 5 цаг суугаад байхаар яаж ажил явах вэ дээ. Хотод машин багтаах ганцхан арга нь татвар нэмэх.



Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.

The Defacto Gazette

БААСАН ГАРАГ БҮР

Улс төр, эдийн засгийн дүн шинжилгээний, бие даасан,
улс төрийн намаас хараат бус долоо хоног тутмын сонин

МАНАЙ СОНИНЫ 2019 ОНЫ I УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

Нэг улирлын үнэ 30,000 төгрөг

Монгол шуудан компанийн
хэвлэл захиалгын утас

70078916

Вебсайт:

<https://www.mongolpost.mn/>



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com